

ВАГОН ПҮҮ НИЙЛҮҮЛЭХ, УГСРАХ, СУУРИЛУУЛАХ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022.01.19

Улаанбаатар хот

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Цогтцэций өртөөний Гаалийн хяналтын бүсэд байрших 200 тн хүртэлх даацтай статик вагон электрон жин шинээр суурилуулах		
№	Төрөл	Тавигдах шаардлагууд
1	Хүчин чадал	<p>Электрон вагон жин нь олон улсын хууль эрх, хэмжилзүйн байгууллагаар зөвшөөрөгдсөн OIML сертификаттай, Монгол орны эрс тэс уур амьсгалын нөхцөлд тохирсон, МУ-ын стандартын шаардлагад бүрэн нийцэж загварын туршилтад тэнцсэн байна. Мөн мэдрэгч, заагч толгой, компьютер, принтер, программ хангамж, пүүнд зориулагдсан төмөр замын зам төмөр гэх мэт цогц 200 тн хүртэл жинлэх статик вагон жинг нийлүүлэх, түүний эд ангийг угсарч суурилуулах, вагон жин нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болох ба сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрийн иж бүрдэл жин байх шаардлагатай бөгөөд хэмжилтийн алдаа 0,05% хүртэл даац нь нэг тэнхлэгт 10-60 тонн хүртэл буюу 200 тонн хүртэл даацтай, төмөр замын аюулгүй ажиллагааны хувьд шаардлага хангасан ачааны галт тэргийг пүүгээр нэвтрүүлэх, пүүлэх байгууламжийн бүтээмжийг сайжруулахад үр дүнтэй суурилуулахад ажиллагаа багатай, программ хангамж нь энгийн, төрөл бүрээр нь тайлан гаргах боломжтой, засвар үйлчилгээ хийхэд хялбар, эвдрэл гэмтэлгүй, оношлоход хялбар байх нь давуу тал болно.</p>
2	Техникийн үзүүлэлт	<p>Р65 зам төмөрт тохирох пүү суурилуулах</p> <p>Тавцангийн нийт урт - 12,5м</p> <p>Тавцангийн өргөн- 1520 мм-н өргөн царигт тохирсон байх</p> <p>Тавцангийн төмрийн зузаан – 200 тонн хүртэл даах</p> <p>Орчин үе, стандартад нийцсэн дижитал мэдрэгчтэй</p> <p>Орчин үе, стандартад нийцсэн дижитал тооцоолууртай байх</p> <p>Датчик холбогч хайрцаг</p> <p>Экрантай утас - +50 хэм даах 20-90% чийглэгт хэвийн ажиллагаатай.</p> <p>Компютер иж бүрэн 19 инчийн ЛСД дэлгэц</p> <p>Дотоодын болон экспортын тээврийн ачааны мэдээлэл боловсруулах боломжтой программ хангамж</p> <p>Принтер</p> <p>Газардуулгатай байх</p> <p>Найдвартай ажиллах хугацаа нь 10 жилээс дээш байх</p> <p>Заагч хэсэг буюу индикатор нь МУ-д ашиглах зөвшөөрлийн гэрчилгээтэй байх</p> <p>Вагон жин нь үйлдвэрийн төмөр тавцантай, электрон авто жин нийлүүлж угсарч суурлилуулах,</p> <p>Төмөр тавцан нь стандартын шаардлагыг хангасан даацтай ямарч төрлийн ачааны вагоны ачааллыг даах чанар болон зузаантай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Камер 6 ком вагоны номер ачааны хэсгийг харах, камер тогтоох шон оворын шаардлагыг хангасан байх “Г” хэлбэртэй - Индикатор луу харсан нэг камерийг төлөвлөх - Камер нь гаалийн ерөнхийн газраас газраас шаардлагад нийцсэн байх/

3	Вагон пүүний операторийн байр	<ul style="list-style-type: none"> - Пүүний удирдлагын байр нь өндөр метал тавцан дээр байрлана. Метал тавцангийн өндөр 2,05м, урт өргөн нь 5.0*5.0м хэмжээтэй байна. Удирдлагын байр нь 4 улиралд ашиглах зориулалттай, 3.0м х 3.0м хэмжээтэй шалны халаалт болон тосон тень давхар халаалттай байна. - Цахилгааны кабель утсыг голчийг зураг төслийн шатанд зөвшөлцөх - Стандарт шаардлага хангасан ажлын байрны ширээ, сандлыг нийлүүлэх
4	Суурийн барилгын ажил	<p>Үйлдвэрлэгчээс баталгаажсан суурийн зурагтай байх батлагдсан зураг төсвийн дагуу барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх.</p> <p>Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрлийг авч ил далд ажлын акт материалын сертификат гүйцэтгэлийн зураг үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>Суурийн бетоны марк зураг төслийн дагуу шаардлага хангасан байх, лаборатороор бетоны шоо авч шинжлүүлэх</p> <p>Суурь бетоны ачаалал авахгүй хэсгийн өндөр газраас түвшинээс 15 см -ээс багагүй байна.</p> <p>Суурь бетоны ачаалал авах хэсгийн өндөр газраас түвшинээс 35 см багагүй байна</p> <p>Суурь бетоны ачаалал авах 8 цэгт, 2см ээс дээш зузаан , голдоо нүхтэй төмөр хавтан байрлуулах</p>
5	Орчны тохижилт	<ul style="list-style-type: none"> - Вагон жингийн орчины 4 талд Төмөр замын оврын шаардлагад нийцүүлэн 6м өндөрт 500вт лед гэрэл суурилуулах. - Вагон жингийн тавцан цацардаг гэрлээр хүрээлэгдсэн байна. - Цахилгаан хангамжийн хувиарлах самбар /8 гаргалгаатай, гүйдлийн тавилын тооцоог зураг төслийн шатанд тооцоогоор сонгох/суурилуулах, - Ачилт буулгалтын талбайн хувиарлах самбараас кабель шугмаар тус самбарыг тэжээх.Тэжээлийн кабель шугмын уртыг 400метрээс багагүйгээр тооцох. - Тус хэсгийн цахилгаан хангамжийн самбар нь төмөр замуудыг огтолж байгаа тул төмөр замтай огтлолцох хэсгийг кабель шугмаар төмөр замын доогуур даацын зориулалт бүхий хос ган хоолойд /ф150-иас багагүй байхаар төлөвлөх/ сүвлэхээр тооцох - Газардуулгын байгууламжыг ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэх
6	Хяналт	<p>Суурилуулсан статик вагон жинг мэргэжлийн байгууллагаар батлагаажуулж хүлээлцэх / Ажил хүлээлцэх акт гаргах үед улсын баталгаажуулалтад хамруулах, /</p> <p>Вагон жин дээр жинлэх үед пүүний оператор гэрэл дохиогоор удирдахаар тоноглогдсон байна.</p> <p>24 цагаар ажиллах боломжтой радио узель өндөр хүчин чадалтай чанга яригч суурилуулах</p> <p>Вагон жингийн мэдээлэл дамжуулах болон гэрэлтүүлэг, дохионы цахилгаан утас гадуураа хамгаалалттай байна.</p>

7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Туршилтын журмаар 14 хоногийн хугацаанд уг вагон жингээр тээврийн хэрэгслийг нэвтрүүлж шалгах бөгөөд туршилтын хугацаа дууссаны дараа эрх бүхий улсын байцаагчаар вагон жинг баталгаажуулах ажлыг зохион байгуулж акт үйлдэн тамга дарж ажлын комисст хүлээлгэн өгнө. Үүнтэй холбогдон гарах зардлыг гүйцэтгэгч хариуцна. Статик вагон жингийн даац нуруу тулгуур тавцангийн даац тооцооны баталгаа материалын сертификатыг дүрмийн дагуу акт үйлдэн хүлээлгэн өгнө. - Вагоны пүүнд тавигдах шаардлагатай зарим тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн шаардлагад нийцүүлэх. Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн техникийн шаардлагыг ажлын даалгаварт хавсаргав. - Барилгын ажил дуусмагц холбогдох бичиг баримтыг захиалагчид норм, дүрэм стандартын дагуу хүлээлгэн өгөх - Холбогдох бүх тоног төхөөрөмжийн гэрчилгээ, заавар, техникийн бичиг баримтыг монгол хэл дээр өгөх - Хурдан гэмтэж эвдэг тоног төхөөрөмжийн нөөцийг тусгах - Боловсруулсан баримт бичгийг захиалагч байгууллагад 3% хэвлэмэл байдлаар мөн Файл хэлбэрээр хүлээлгэн өгнө.
8	Тусгай зөвшөөрөл	Стандарт хэмжил зүйн газрын вагон жин нийлүүлэх, суурилуулах тусгай зөвшөөрөлтэй байх.
9	Зураг төсөв	Вагон жингийн суурь суурилуулалтын ажлын зургийг, эрх бүхий байгууллагаар батлуулсан байх
10	Төслийн шат үе	Гэрээнд заасан хугацаанд 1 үе шаттай байна.